

**ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН САЙД, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2012 оны 02 дүгээр сарын 01 өдөр

Дугаар А/22/23 Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 8.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Жолоочийн даатгалын баталгааны загварыг хэрэглэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Жолоочийн даатгалын баталгааны загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалыг 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэ журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газар /С.Ганболд/, Албан журмын даатгагчдын холбоо /Б.Мөнхбаатар/, Цагдаагийн ерөнхий газар /Д.Сандаг-Очир/-т тус тус даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД

Ц.НЯМДОРЖ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

*Хууль зүй, дотоод хэргийн сайд,  
Санхүүгийн зохицуулах хорооны даргын  
хамтарсан 2012 оны 02 дугаар сарын 01-  
ний өдрийн А/22/23 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт*

## **ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН БАТАЛГААНЫ ЗАГВАРЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ журмаар жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын баталгаа /цаашид “даатгалын баталгаа” гэх/-ны загвар, түүнийг хэрэглэх, хэвлүүлэх, тараах, даатгалын баталгааны зарцуулалтад хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### **Хоёр. Нэр томъёоны тайлбар**

2.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно:

2.1.1. “жолооч” гэж Жолоочийн даатгалын тухай хуулийн 3.1.1-т заасныг;

2.1.2. “даатгагч” гэж Жолоочийн даатгалын тухай хуулийн 3.1.3-т заасныг;

2.1.3. “даатгуулагч” гэж Жолоочийн даатгалын тухай хуулийн 3.1.4-т заасныг;

2.1.4. “автотээврийн хэрэгсэл” гэж Жолоочийн даатгалын тухай хуулийн 3.1.2-т заасныг;

2.1.5. “даатгалын баталгаа” гэж даатгагч жолоочийн даатгалын гэрээ байгуулсныг гэрчлэн даатгуулагчид өгөх баримтыг;

2.1.6. “эрх бүхий этгээд” гэж даатгалын баталгааг захиалах, хэвлэх, тараах, бүртгэл хөтлөх болон түүнтэй холбоотой асуудлыг хариуцсан Албан журмын даатгагчдын холбоо /цаашид “Холбоо” гэх/ болон даатгагчаас томилогдсон этгээдийг;

2.1.7. “зураасан тэмдэгт” гэж тухайн даатгуулагчийн талаарх мэдээллийг хураангуйлсан олон улсын стандартын дагуу хэвлэгдсэн зураасан тэмдэглэгээ, тоон мэдээллийн илэрхийлэгч;

2.1.7. “RFID” гэж тухайн даатгуулагчийн талаарх мэдээллийг цахим байдлаар илэрхийлэх түлхүүр үг, кодчилолыг агуулсан олон улсын стандарт шаардлагын дагуу үйлдвэрлэгдсэн ялтас гэж ойлгоно.

### **Гурав. Даатгалын баталгааны загвар**

3.1. Даатгалын баталгаа нь даатгуулагч, даатгагч, хяналт шалгалтын ажилтнуудад илт харагдахуйц байрлал /салхины шилний баруун дээд өнцөгт, ил харагдах хэсэгт/-д наагдахуйц тухайн даатгал авагдсан он, соёмбо бүхий, зураасан тэмдэгтээр хураангуйлан тухайн даатгал, татвар, үзлэг, оношилгооны

талаарх мэдээллийг агуулж, радио давтамжит танигч RFID (Radio-frequency identification) –тай байна. /Хавсралт 1–д заасан загвар/.

3.2. Даатгалын баталгааны урт нь CR80 стандарт хэмжээ бүхий 85 мм, өргөн нь 55 мм, даатгалын оны үсгийн өндөр нь 16 мм хэмжээтэй, үсгийн бичиглэлийн өргөн нь 39 мм хэмжээ бүхий, тэгш тоотой жилд улаан, сондгой тоотой жилд хөх өнгөөр, даатгалын баталгааны хуудасны дэвсгэр өнгө нь тэгш тоотой жилд цэнхэр, сондгой тоотой жилд улаан өнгөөр, голд байрлах соёмбо нь алтлаг шаргал өнгийн нууцлал бүхий хэвлэмэл наалт байх бөгөөд өндөр нь 38 мм, өргөн нь 20 мм –ийн хэмжээтэй, зураасан тэмдэгтийн хэмжээ 21 мм өндөр, 42 мм өргөнд багтаж байхаар, хажуу хүрээгээр түмэн наст хээг цагаан өнгөөр хэвлэнэ.

3.3. Даатгалын баталгааны ар талын хэсэгт даатгалын баталгааны хуудсын үйлдвэрлэлийн үед өгөгдсөн үнэт цаасны бүртгэл, даатгуулагчид өгөх санамж байна.

3.4. Даатгалын баталгаа нь үнэт цаасны нууцлалын түвшинд хэвлэгдэж, зураасан тэмдэгтээр даатгуулагчийн мэдээллийг илэрхийлж, цахим ялтсаар дамжуулан технологээр мэдээлэл солилцох боломжтой байна.

### **Дөрөв. Даатгалын баталгааг хэрэглэх**

4.1. Даатгуулагч нь “Даатгалын баталгаа” -г автотээврийн хэрэгслийн салхины шилний баруун дээд буланд, ил харагдахуйц хэлбэрээр байршуулж, эрх бүхий этгээд техник, тоног төхөөрөмжөөр болон биечлэн шалгах боломжийг бүрдүүлсэн байна.

4.2. Даатгалын баталгааны хуудсанд даатгалын болон даатгуулагчийн талаарх мэдээллийг зураасан тэмдэг болон (RFID) ялтсанд оруулсаны дараа түүнийг даатгуулагчид өгнө.

Даатгуулагчийн зүгээс даатгалын хугацаа дууссан, даатгалын шинэ баталгаа авах, даатгалын баталгааг шалгах үед хууль бус мэдээлэл илэрсэн, үрэгдүүлсэн зэрэгт зөрчлийг арилгаж, дахин сольж авна.

4.3. Энэ журмын 3.1-д заасан баталгааны хуудсыг даатгуулагчтай жолоочийн даатгалын гэрээ байгуулсан даатгагч бөглөж даатгуулагчид хүлээлгэн өгнө.

### **Тав. Даатгалын баталгааны захиалга авах, хянах, хэвлэлийн компанид захиалга өгөх, хэвлүүлэх**

5.1. Даатгалын баталгааны захиалгыг Холбоо нь албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагчаас /цаашид “даатгагч” гэх/ улиралд нэг удаа авна.

5.2. Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Холбоонд даатгалын баталгааг захиалахдаа дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна:

5.2.1. тухайн даатгагчийн дараагийн улиралд хэрэглэх даатгалын баталгааны хэрэгцээт тоо хэмжээг захиалсан захиалгын хуудас;

5.2.2. жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн Хорооны тогтоолын хуулбар /Анх удаа захиалга өгч байгаа тохиолдолд ирүүлэх/;

5.2.3. өмнөх улиралд захиалсан даатгалын баталгааны зарцуулалтын тайлан;

5.2.4. өмнөх улиралд захиалсан даатгалын баталгааны үлдэгдлийн тайлан.

5.3. Даатгагч нь дараагийн улиралд хэрэглэх даатгалын баталгааны хэрэгцээт тоо хэмжээний захиалгаа энэ журмын 5.2-т заасан баримт бичгийн хамт бүрдүүлэн дараагийн улирал эхлэхээс 45-аас доошгүй хоногийн өмнө Холбоонд ирүүлнэ.

5.4. Холбоо нь даатгагчаас ирүүлсэн даатгалын баталгааны захиалгыг дараах тохиолдолд буцаана:

5.4.1. энэ журмын 5.2-т заасан баримт бичгийг бүрдүүлээгүй болон дутуу бүрдүүлсэн;

5.4.2. Хорооноос албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл аваагүйгээд баримт бичиг ирүүлсэн;

5.4.3. албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон;

5.4.4. жолоочийн даатгалын санд төлөх хураамжаа төлөөгүй /Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.1-д заасан хөрөнгө/;

5.4.5. Холбоонд төлөх элсэлтийн хураамж, гишүүний татвараа төлөөгүй;

5.4.6. даатгалын баталгааг зүй бусаар ашигласан нь тогтоогдсон.

5.5. Даатгалын баталгааг батлагдсан загварын дагуу хэвлэх захиалгыг Холбоо хэвлэлийн компанид өгнө.

5.6. Холбоо нь даатгагчаас ирүүлсэн даатгалын баталгааны хэрэгцээт тоо хэмжээний захиалгыг хянаж, захиалгыг нэгтгэн бодит хэрэгцээг үндэслэлтэй тогтоож, дараагийн улирал эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө хэвлэлийн компанид захиалга өгч хэвлүүлнэ.

5.7. Даатгалын баталгааг хэвлэх компанийг Холбооноос Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулна.

5.8. Хэвлэлийн компани нь захиалгад дурдсанаас өөр сери бүхий даатгалын баталгаа хэвлэх, захиалсан тооноос илүү болон дутуу хэмжээгээр хэвлэх болон Холбооноос бусад этгээдийн захиалгаар даатгалын баталгаа хэвлэхийг хориглоно.

5.9. Даатгалын баталгаан дээр гэрээний дугаарыг бичих бөгөөд дугаарлах зааврыг Холбоо баталж, мөрдүүлнэ.

5.10. Холбоо даатгалын баталгаан дээр гэрээний дугаар олгох зааврыг батлахдаа Хорооны Даатгалын газарт хянуулж, зөвшөөрөл авсан байна.

### **Зургаа. Холбооны үүрэг**

6.1. Холбоо нь дараах үүрэгтэй:

6.1.1. энэ журмын 5.6-д заасан хугацааны дотор даатгалын баталгаа хэвлүүлэх захиалгыг хэвлэлийн компанид өгөх;

6.1.2. даатгалын баталгааны захиалгаболон бүртгэлийг хариуцсан эрх бүхий этгээдийг томилох;

6.1.3. даатгалын баталгааг захиалсан болон даатгагчид тараасан, даатгагчидтай даатгалын баталгааг эргэж тооцсон талаарх мэдээллийг сери, гэрээний дугаар бүрээр тооцсон бүртгэл хөтлөх;

6.1.4. даатгалын баталгааг хэвлэлийн компаниас хүлээж авахад баталгаа нь гэмтсэн, дутсан, илүү гарсан, сав баглаа боодол нь задарсан гэх мэт аливаа зөрчил гарсан тохиолдолд уг зөрчлийг бүртгэн, 2 талын гарын үсэг бүхий тэмдэглэл үйлдэх;

6.1.5. даатгагчаас ирүүлсэн гологдолтой даатгалын баталгааг сери, гэрээний дугаар бүрээр бүртгэн хүлээн авах, устгах, актлах, нөхөж хэвлүүлэх асуудлыг зохион байгуулах.

6.2. Холбоо нь даатгалын баталгааг даатгагчид тараасан болон даатгалын баталгааны дүнг тооцсон талаарх тайланг дараах баримт бичгийн хамт улирал тутамд буюу Даатгалын тухай хуулийн 32.1-д заасан хугацаанд Хороонд ирүүлж, хянуулна:

6.2.1. даатгагчаас ирүүлсэн дараагийн улиралд хэрэглэх даатгалын баталгааны хэрэгцээт тоо хэмжээг захиалсан захиалгын хуудасны хуулбарыг даатгагч бүрээр гаргаж ирүүлэх;

6.2.2. сонгон шалгарсан хэвлэлийн компанид захиалсан даатгалын баталгааны захиалгыг сери тус бүрээр гаргаж ирүүлэх;

6.2.3. даатгалын баталгааны захиалгыг хэвлэлийн компаниас хүлээж авсан 2 талын гарын үсэг бүхий баримт;

6.2.4. даатгалын баталгааг захиалгын дагуу даатгагчдад тараасан талаарх 2 талын эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий баримт;

6.2.5.даатгалын баталгааг хэвлүүлсэн төлбөрийг хэвлэлийн компанид тушаасан баримтын хуулбар;

6.2.6.даатгагчаас Холбоонд тушаасан даатгалын баталгааны төлбөрийн баримтын хуулбар;

6.2.7.энэ журмын 6.1.4-т заасан зөрчил гарсан тохиолдолд уг зөрчлийг бүртгэсэн, акталсан талаарх 2 талын гарын үсэг бүхий тэмдэглэлийн хуулбар.

6.2.8.Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг.

6.3. Энэ журмын 6.2-т заасан баримт бичгийг Хороо хянаж бүртгэлд авна.

### **Долоо. Даатгагчийн үүрэг**

7.1. Даатгагч нь дараах үүрэгтэй:

7.1.1.захиалсан даатгалын баталгааны үнийг Холбоонд тушаах;

7.1.2.даатгалын баталгааны захиалгаболон бүртгэлийг хариуцсан эрх бүхий этгээдийг томилох;

7.1.3.Холбооноос хүлээж авсан даатгалын баталгааны сери, олгосон гэрээний дугаар бүрээр бүртгэл хөтлөх;

7.1.4.даатгалын баталгааны хэрэглээ, зарцуулалтыг сери, гэрээний дугаар бүрээр Холбоонд тайлагнах;

7.1.5.Холбооноос авсан даатгалын баталгааны тоо, ширхэгийг дутаахгүй, хууль бусаар зарцуулахгүй, ашиглан шамшигдуулахгүй байх;

7.1.6.энэ журмын 4.1-д заасан даатгалын баталгааг хэрэглэх зааварчилгааг даатгуулагчид өгөх.

### **Найм. Даатгалын баталгааны хуудсанд агуулагдах мэдээлэл**

8.1.Даатгалын баталгааны мэдээлэл нь цахим болон зураасан тэмдэгтээр илэрхийлэгдэнэ.

8.2.Цахим мэдээлэл нь тухайн даатгуулагч, даатгагчийн талаарх мэдээллийг товч байдлаар агуулсан, хүчинтэй хугацаа, даатгалын талаарх мэдээллийг агуулсан байх бөгөөд цахим чипэнд бичигдэнэ.

8.3.Цахим чип нь түүнд бичигдсэн мэдээллийг эрх бүхий албан тушаалтнуудаас тухайлсан тоног төхөөрөмжийг ашиглан шалгах, мэдээллийг өөрчлөх, боломжоор хангагдсан байна.

8.4.Зураасан тэмдэгт нь тухайн даатгалын талаарх бүх мэдээллийг агуулсан байх бөгөөд бүртгэлийн ажиллагаа бүрэн дууссаны дараа зориулалтын хэвлэгчээр хэвлэж, шалгаж олгоно.

8.5.Үрэгдүүлсэн болон гэмтээсэн цахим болон зураасан тэмдэгтийг сольж олгоходоо мэдээллийг шинээр оруулах бөгөөд энэ тохиолдолд мэдээллийн сангаас мэдээллийг оруулна.

## Ес. Хяналт, хариуцлага

9.1. Энэ журмын биелэлтэд Хорооны даатгалын хяналтын улсын байцаагч хянан шалгагч болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын албаны улсын байцаагч хяналт тавьж ажиллах бөгөөд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---ooOoo---

*Хууль зүй, дотоод хэргийн сайд,  
Санхүүгийн зохицуулах хорооны даргын  
хамтарсан 2012 оны 02 дугаар сарын 01-  
ний өдрийн А/22/23 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт*

### Жолоочийн даатгалын баталгааны загвар

